



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠳᠤ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 11/2023

Алтай хот

**Хүүхдийн спортын VII наадам
 зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам", Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны А/254 дүгээр тушаалыг үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Алтай хотноо 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэл зохион байгуулагдах Хүүхдийн спортын VII наадам зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, нэгдсэн зааврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Наадмыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг зохион байгуулах хороо (С. Мөнхжаргал)-нд үүрэг болгосугай.

3. Хүүхдийн спортын наадам зохион байгуулах хорооны үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж, баг тамирчдаа оролцуулахыг сумдын Засаг дарга, сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 сарын 13-ны өдрийн 1162 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХҮҮХДИЙН СПОРТЫН VII НААДАМ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Хорооны дарга: (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
- Гишүүд: (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)
(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга)
(Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)
(Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд, спортын бодлого хариуцсан мэргэжилтэн)
(Спорт холбоодын тэргүүнүүд)
- Нарийн бичгийн дарга: (Биеийн тамир, спортын газрын дарга)

__оОо__

Аймгийн Засаг даргын 20²³ оны 03
сарын 15-ны өдрийн 1722 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

Нэг. Зорилго

Биеийн тамир, спортын тухай хуулийн 16.1, Бага дунд боловсролын тухай хуулийн 18.3 дугаар заалтыг тус тус үндэслэн, өсвөр үеийнхнийг тэмцээн наадамд өргөнөөр оролцуулах, "Аваргыг Алтайдаа" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах, Монголын хүүхдийн спортын VII наадамд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах, ур чадвартай тамирчдын залгамж халааг тодруулан гаргахад оршино.

Хоёр. Зохион байгуулалт, мэдүүлэг хүлээн авах журам

Хүүхдийн спортын VII наадмыг Биеийн тамир, спортын газрын багш дасгалжуулагчид зохион байгуулна.

Сум, сургуулийн тамга, тэмдэг бүхий мэдүүлэг, мэдүүлэгт регистрийн дугаарыг заавал оруулсан байна. (тамирчид 3x4 хэмжээтэй цээж зураг 1 хувь заавал авч ирнэ)

Мандатны үнэ 5000 төгрөг байх ба баг, тамирчдын хоол, байр, унааны зардлыг тэмцээнд оролцуулж буй үндсэн байгууллага, сум сургууль бүрэн хариуцна.

Мэдүүлгийг: 2023 оны 01 дүгээр сарын 12-15-ны өдөр, 03 дугаар сарын 01-ний өдөр, 04 дүгээр сарын 21-ний өдрүүдэд тус тус Биеийн тамир, спортын газарт хүлээн авна.

Гурав. Хугацаа


2023 оны 02 дугаар сарын 08-12-ны өдрүүд, 03 дугаар сарын 02-05-ны өдрүүд, 04 дүгээр сарын 22-23-ний өдрүүдэд Биеийн тамир, спортын газарт болно.

Дөрөв. Шагнал урамшуулал

Тэмцээний эхний 4 байр эзэлсэн баг тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, ергөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

12.	Ширээний теннис	III/02-05	8-с доош нас эр, эм, 9-10 нас эр, эм, 11-12 нас эр, эм, 13-15 нас эр, эм, 16-18 нас эр, эм	
13.	Хөнгөн атлетик	IV/22-23	Хөвгүүд: 100м, 200м, 400м, 800м, 1500м, 5000м, уртын харайлт, 3-ын харайлт, бөөрөнцөг түлхэлт. Охид: 100м, 200м, 400м, 800м, 1500м, 3000м, уртын харайлт, 3-ын харайлт бөөрөнцөг түлхэлт.	2006.01.01- нээс хойш төрсөн охид, хөвгүүд оролцоно.
14.	Мини волейбол	IV/22-23	Бага нас: эр -4, эм-4 Ахлах нас: эр -8, эм-8	12 ба түүнээс доош нас, Ахлах нас 13-14.
15.	Хөлбөмбөг	IV-V сард	10-12 нас охид хөвгүүд /grassroots/ 14, 16 нас охид, хөвгүүд. 13-15 нас хүртэл охид, хөвгүүд 8 тамирчин, сэлгээ 2 тамирчин 1 дасгалжуулагч.	(18 нас хүртэл лигийн тэмцээн эрэгтэй баг) Гадна талбайд

Тав. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах
тэмцээний график төлөвлөгөө



№	Спортын төрөл	Хугацаа	Насны ангилал, жин	Тэмцээний тодотгол
1.	Үндэсний сур	ҮИИ/10.11	2 насны ангиллаар	11-14 нас 15-18 нас
2.	Үндэсний бөх	IX сард	3 насны ангиллаар зохион байгуулагдана.	16 нас 2006.11.01-ээс 2007.11.01-ний хооронд төрсөн. 17 нас 2005.11.01-ээс 2006.11.01-ний хооронд төрсөн 18 нас 2004.11.01-ээс 2005.11.01-ний хооронд төрсөн.
3.	Волейбол	I/12-15	Хөвгүүд -8, охид -8, Дасгалжуулагч -1	17 нас хүртэл
4.	Даам	I/12-15	5-7, 8--10 нас, 11-13 нас, 14-17 нас	Аймгийн төвд Охид-1, хөвгүүд -1,
5.	Чөлөөт бөх	I/12-15	Хөвгүүд: 45,48,51,55,60,65,71,80,92, 110 Охид:40,43,46,49,53,57,61,65,69, 73 кг жингийн зөрүүгүй	2006.01.01-2008.12.30 хооронд төрсөн
6.	Самбо бөх	I/12-15	Хөвгүүд: 53кг, 58кг, 64кг, 71кг, 79кг, 88кг, -98кг, +98кг Охид: 47кг, 50кг, 54кг, 59кг, 65кг, 72кг, -80кг, +80кг	2006.01.01-с хойш төрсөн охид, хөвгүүд
7.	Шатар	I/12-15	6 хүртэл холимог, 7-8 нас, 9-10 нас, 11-12 нас, 13-14 нас, 15-16 нас, 17-18 нас.	
8.	Жү-до бөх	III/02-05	Баганас: 2011, 2012 он Хөвгүүд: -27кг, -30кг, -34кг, -38кг, -42кг, -46кг, -50кг, -55кг, -60кг, +60кг Охид: -32кг, -36кг, -40кг, -44кг, -48кг, -52кг, -57кг, -63кг, +63кг Дунднас: 2009, 2010 он Хөвгүүд: -42кг, -46кг, -50кг, -55кг, -60кг, -66кг, -73кг, +73кг Охид: -36кг, -40кг, -44кг, -48кг, -52кг, 57кг, -63кг, +63кг Ахлахнас: 2006, 2007, 2008 он Хөвгүүд: -50кг, -55кг, -60кг, -66кг, -73кг, -81кг, -90кг, +90кг Охид: -40кг, -44кг, -48кг, -52кг, -57кг, -63кг, -70кг, +70кг.	
9.	Сагсан бөмбөг 5x5	III/02-05	Хөвгүүд -7, охид -7 дасгалжуулагч-1	16-17 нас
10.	Таеквондо	III/02-05	Хөвгүүд: 20, 25, 30, 35, 40, 45, 50, 55, 60 Охид: 30, 36, 42, 48, 52	Өсвөр бага нас
11.	Сагсан бөмбөг 3x3	III/02-05	Хөвгүүд -4, охид -4 дасгалжуулагч-1	16-17 нас